



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 01

Дугаар А/4

Амардалай

Г Дуудлага худалдаа зохион байгуулах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, 36 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, сумын Газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Тус сумын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар шинээр эзэмшүүлэх газрын дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: З.Наранмандах /Засаг даргын орлогч/

Хөтлөгч: Л.Мөнхсарнай /Газрын даамал/

Тэмдэглэл хөтлөгч: Б.Баярмаа /Архив бичиг хэрэг/

Хоёр. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах ажлын журам, зааврыг баримтлан ил тод нээлттэй явуулахыг ажлын хэсгийн дарга /З.Наранмандах/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ЦОЛМОНБААТАР